

“Стратегийн бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд хэлэлцэх асуудлын ерөнхий агуулга:

1. Монгол Улсын стратегийн гол нэрийн бүтээгдэхүүн, түүний чанар, аюулгүй байдал
2. Үр тариа, тэжээлийн ургамлын чанар, аюулгүй байдал
3. Агуулахын стандарт, барилгын хийц, бүтэц зохион байгуулалт
4. Лаазалсан хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал
5. Шатах, тослох материалын аюулгүй байдал

Өгүүлэлд тавигдах шаардлага:

1. Шинжлэх ухааны үндэслэлтэй байх
2. Эрдэм шинжилгээний өгүүллийн заавраар бичигдсэн байх
3. Онол, арга зүйн асуудлыг хөндсөн байх
4. Асуудал дэвшүүлж, тодорхой үр дүнд хүрсэн байх
5. Шинэ мэдлэг, инновац шингэсэн байх

Өгүүлэл бичих заавар:

Өгүүллийг зөвхөн Microsoft Word 2003 программ буюу түүнээс хойших хувилбар дээр *.DOC буюу *.DOCX өргөтгөлтэй форматыг ашиглан Times New Roman үсгийн фонтоор 11pt үсгийн өндрийг сонгон бичнэ. Мөрүүд нь баруун, зүүн талдаа (2 баганад) зэрэгцэн бичигдэнэ.

Эрдэм шинжилгээний өгүүлэл (ЭШӨ) дараах хэсгүүдтэй байна. Үүнд:

Өгүүллийн нэр: Өгүүллийн нэрийг 11 хэмжээтэй, (Bold), мөр голлоно.

- ✓ ЭШӨ-ийн нэр нь тодорхой мэдээлэл өгөгдөхөөр байх ёстой.
- ✓ ЭШӨ нэр дотор товчилсон үг тавихгүй.

Зохиогчийн нэр хаяг: Зохиогчдын нэрийн баруун дээд өнцөгт тоогоор дугаарлан тэмдэглэж, нэрсийн дор албан газрын нэр бичсэн байна. 1-р зохиогчийн цахим хаяг, холбогдох утасны дугаарыг бичсэн байх.

- ✓ Зохиогчийн листэд орсон хүнийг талархалд оруулахгүй.
- ✓ Судалгааны ажлыг төлөвлөж гүйцэтгэсэн, өгүүллийг бичсэн, өгүүллийг бүтнээр болон хэсэгчлэн хянасан, сүүлчийн хувилбарыг зөвшөөрсөн хүнийг зохиогчоор оруулна.
- ✓ Зохиогчийн дарааллыг тухайн бүтээл дэх оролцоог харгалзан хийнэ.
- ✓ Нэг байгууллага байгаа тохиолдолд цифр болон тэмдэглэгээ тавихгүй.
- ✓ Байгууллагын нэрийг товчлол хэлбэрээр бичихгүй.

Хураангуй: Зорилго, таамаглал, арга, аргачлал, үр дүн, дүгнэлт гэсэн бүтэцтэй байх.

- ✓ Хураангуйд ном зүй (ишлэл) оруулахгүй.
- ✓ Хураангуйг 15 мөр, 200-250 үгэнд багтаан бичнэ.

Түлхүүр үг: Өгүүллийн утга санааг гаргахуйц, ганц тоогоор илэрхийлсэн нэр үг байна.

- ✓ Тухай өгүүллийн утгыг илэрхийлж чадахуйц 5-8 ширхэг нэр үг, ганц тоон дээр бичигдэнэ.
- ✓ Өгүүллийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй.

Оршил: Судалгааны ажлын үндэслэл, шинэлэг тал, зорилго зэргийг бичнэ.

- ✓ Тулгамдаж буй асуудал юу вэ? Яагаад энэ асуулт нь тийм сонирхолтой байна вэ? Энэ асуудлын хүрээнд шийдвэрлэгдээгүй зүйл нь юу вэ?
- ✓ Өөрийн судалгааны асуулт эсвэл таамаглалыг тусган 3 параграфад багтаана.

Судалгааны материал, арга зүй: Сонгосон судалгааны хэрэглэгдэхүүн,

хэрэглэсэн арга зүй, товч тайлбар, статистик боловсруулалт ямар аргаар хийгдсэн зэрэг багтана.

Судалгааны үр дүн: Өөрийн судалгааны дүнг тодорхой бичих үр дүнгийн тайлбарыг давхардуулахгүй байх.

- ✓ Үр дүндээ өөрийн дэвшүүлсэн таамаглалаа бататгаж чадсан эсэхээ бичнэ.
- ✓ Үр дүнгээ зураг, хүснэгт юугаар илэрхийлэхээ сонгоно.
- ✓ Зураг болон хүснэгтийнхээ гол хэсгийг л тайлбарлаж бичнэ.
- ✓ Зураг болон хүснэгтийг хар цагаанаар илэрхийлнэ.
- ✓ 1-р зураг, 1-р хүснэгт, 1-р график гэх мэтчилэн дугаарлана.
- ✓ Судалгаанд 25-аас доош объект байгаа тохиолдолд хувиар илэрхийлэхгүй.
- ✓ Голдуу, ихэнхдээ гэсэн үг хэрэглэхгүй, ерөнхий зүйл бичихгүй.

Хэлэлцүүлэг: Судалгааны үр дүнг бусад судлаачдынхтай харьцуулсан байх.

- ✓ Судалгааныхаа хамгийн гол үр дүнг бусад судлаачдынхтай харьцуулж бичнэ.
- ✓ Тоон үзүүлэлтийг тоон үзүүлэлттэй харьцуулахдаа арга зүйн зөрүү, гадаад, дотоод орчны ялгаа, ашигласан эм урвалж зэргийг сайтар нягталж, хэлэлцүүлэгт тусгах нь зүйтэй.
- ✓ Яагаад ийм үр дүн гарав гэдгийгээ маш сайн тайлбарла.
- ✓ Судалгааны ажлын сул болон давуу талаа тусгах хэрэгтэй.

Дүгнэлт: Өөрийн судалгааны ажлын дүгнэлтийг үндэслэлтэйгээр товойлгон гаргасан байх.

Иш татсан бүтээлийн жагсаалт: Иш татсан бүтээлийн жагсаалтыг Харвардын систем буюу цагаан толгойн дэс дарааллаар хийнэ (Зохиогчийн нэрийн эхний үсэг болон он дарааллын систем)

- ✓ Зохиогчийн нэр, овгийн эхний үсэг, он, дугаар, хуудас зэргийг тодорхой бичсэн байх, мөн (“google, pubmed.com” гэх мэт ерөнхий веб хуудасны нэрийг бичихгүй Link-ийг тодорхой бичих)
- ✓ Зүүлт тайлбарын тоо тус тусдаа мөрийн дээд тэмдгээр илэрхийлэгдэнэ. Нэмэлт тайлбар (footnote)-ыг тухайн дурдсан баганынхаа доод талд байрлуулна, ишлэлийн жагсаалтад оруулахгүй.
- ✓ Бүтээлийг ишлэхдээ
 - Нэг зохиогчтой бол: (Chandley, 2015), (Өлзийхутаг, 1988)
 - Хоёр зохиогчтой бол: (Chandley and Speed, 2015), (Дорж ба Дулам, 1990) Хоёроос илүү зохиогчтой бол: (Hale *et al.*, 2006), (Сүрэн нар., 2009)
 - Нэг онд хэвлэгдсэн бүтээлийг (Goulet and Beynon, 2014a, b)
 - Олон ишлэл нэг дор авах бол: (Evans, 1975; Mittwoch, 1992; Пунцагдулам, 2005; Болд, 2016;) гэж бичнэ.

Summary (in English): Өгүүллийн нэр, зохиогчийн нэр, албан байгууллагын нэр, өгүүллийн товч утгыг англи хэл дээр 200-250 үгэнд багтаан бичсэн байх. Түлхүүр үг (Keywords)-тэй байна.

Санамж

1. ЭШӨ 257x182 мм (B5) хэмжээтэй 5-9 хуудсанд багтсан байна.
2. Өгүүллийг зөвхөн MSWord 2003-аас хойших хувилбараар *.doc буюу *.docx өргөтгөлтэй форматыг ашиглан Times New Roman фонтоор бичнэ.
3. Өгүүллийг **B5** хэмжээний цаасан дээр хуудасны дээд, доод, баруун, зүүн талаас 2.0 см зайг үлдээж бичнэ. Өгүүллийг бичихдээ header, footer, footnote командыг ашиглахгүй. Мөн хуудасны дугаарыг тавихгүй.
4. Зүйл нь шинэ мөрнөөс, мөрний эхнээс эхлэх ба мөрүүд хоорондоо 1sp зайтай байна.
5. Бүх математик бичлэгүүд MS Equation, MathType, LaTeX программаар бичигдэх бөгөөд 11pt өндөртэй байна. Томьёо нь дээд, доод талаасаа 11pt

зайтай байх ба мөр голлон бичигдэнэ. Томьёоны дугаарыг тухайн мөрний төгсгөлд бага халтанд бичнэ.

6. Фото зураг, зураг, хүснэгт зөвхөн хар, цагаан өнгөтэй байна. Scanner ашиглаж оруулсан бүдүүвч зураг болон фото зураг 300 dpi нягтаршилтай, зургийн *.TIF, *.JPG, *.BMP, *.GIF өргөтгөлтэйгөөр буулгагдаж, текст дотор мөр голлон байрласан байна. Зураг дээрх үсэг, тооны өндөр нь ерөнхий текстийн үсгийн өндөртэй тэнцүү байх буюу 85%-иас бага байж болохгүй.
7. Нийтээр хэрэглэж заншаагүй товчилсон үгийг өгүүлэлд хэрэглэхгүй байвал зохино.